



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар A/1.

Өвт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 2 дугаар Цэцэрлэгийн хүүхдийн хоол нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын  
байцаагч

Гишүүд: Э.Ууганаа-2 дугаар Цэцэрлэгийн нярав

Л.Балжинням-Багийн Засаг дарга

Д.Алтанцэцэг-Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Г.Болормаа –Эрүүл мэндийн төвийн  
нягтлан бодогч

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Янжиндулам)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бурдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Болормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН